

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

**Бунибазарын Доржийн алдар гавьяаг мөнхжүүлэх, түүний мэндэлсний
150 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Богд хаант засгийн монгол цэргийн “Мэйрэн” цолтой захирагч, Гадаад явдлын яамны эрхэлсэн түшмэл, Монгол Улсын Сангийн сайд, эрдэмтэн, соён гэгээрүүлэгч, улсын сурын анхны мэргэн, төр, нийгмийн нэрт зүтгэлтний мэндэлсний 130 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан түүний алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Бунибазарын Доржийн мэндэлсний 150 жилийн ойг 2028 оны 5 сард тэмдэглэн өнгөрүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр баталж, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

2/ Бунибазарын Доржийн Монгол улсад олон улсын харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, энх тайвныг сахин хамгаалж, улсын санхүү, орлого, зарлага, худалдаа, татварын бодлогыг сайжруулж, улсын сан хөмрөгийг арвижуулах, орлогыг нэмэгдүүлж, улсынхаа тусгаар тогтнол, эрх чөлөөг сэргээн мандуулах үйлсэд оруулсан үнэтэй хувь нэмэр, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

3/ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, төлөвлөсөн холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх арга хэмжээг хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд судалж шийдвэрлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо /Ч.Ундрам/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг